



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 0/31

Даланзадгал

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндсэлэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2017 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг төсвийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч, нийт албан хаагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газар /Ж Даваахүү/-д даалгасугай.

Хавсралт 5 хуудастай.

ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
ХОТЫН ЗАХИРАГЧ



Т.АЛТАНСҮХ

Засаг дарга бөгөөд хотын захирагчийн 2017 оны
02 сарын 07-ны өдрийн 4/дугаар
захирамжийн хавсралт



ДАЛАНЗАДГАД СУМ /ХОТ/-ЫН 2017 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилтууд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хариуцах эзэн
1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт	1.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, батлуулах	2 дугаар сард	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан байна.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх	ЗДТГ болон 8-н баг, харьяа төсөвт байгууллагууд
	1.2. Төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг санхүүжүүлсэн байдал	2 дугаар сард	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилтийг төлөвлөсөн байх	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх санхүүгийн нөхцөл бүрдэх	
	1.3. Батлагдсан төлөвлөгөөг иргэдэд танилцуулах арга хэмжээ	Жилийн турш	Төлөвлөгөөг олон арга хэмжээгээр сурталчилсан байна.	Төлөвлөгөөний талаар иргэд мэдээлэлтэй болсон байна.	
	1.4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлагналт	11 сарын 10-ны дотор	Хугацаандаа тайлагнасан байх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ бодитой хэрэгжсэн байх	
2. Авлигаас ангид байх удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх	2.1. Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлээ илэрхийлж шударга ёсыг тогтоох, авлига хүнд сурталгүй ажиллах талаар албан хаагчдад болон олон нийтэд мэдэгдэл хийсэн байх	Улирал бүр	Мэдэгдэл хийж манлайллыг хэрэгжүүлдэг талаар олон нийт мэдээлэлтэй болсон байна.	Байгууллагын удирдлагад хандах иргэдийн хандлага сайжирна.	ЗДТГ, БЗД нар болон харьяа төсөвт байгууллагуудын удирдлага
	2.2. Төсвийн шууд менежер, ажилтнуудтай хийх үр дүнгийн гэрээнд удирдлагын болон хувь хүний манлайллыг хэрэгжүүлэхтэй холбогдсон заалт оруулах	1 дүгээр сард	Гэрээг дүгнэхэд бодит үзүүлэлт болохуйц заалтуудыг оруулсан байх	Удирдлага болон хувь хүний авлигаас ангид ёс зүйтэй байх, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ахиц гарч, хариуцлага тооцох боломж бүрдэнэ.	
3. Байгууллагын онцлогт тохирсон ёс зүйн	3.1. Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулж, тэдгээрээр гарын үсэг зуруулсан байх	Жилийн турш	Ажиллаж байгаа албан хаагчдад 1 удаа, шинээр томилогдсон тухай бүр.	Бүх албан хаагчид ёс зүйн дүрэмтэй бүрэн танилцсан байна.	Ёс зүйн хороо

хэм хэмжээг батлан мөрдүүлэх	3.2. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, 2017 оны ажлын төлөвлөгөөг баталсан байх	2 дугаар сард	Төлөвлөгөө батлагдсан байна	Байгууллага бүр өөрийн онцлогийг тусгасан ёс зүйн хэм хэмжээг тогтоох	ЗДТГ болон харьяа төсөвт байгууллагын удирдлагууд Хяналт тавих-Ёс зүйн хороо
	3.3. Ёс зүйн дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтийг хариуцлага, хүлээлгэх, урамшуулахад харгалзан үзсэн байх	Жилийн турш	Үйл ажиллагаагаар	Ёс зүйн дүрмийн хэрэгжилт хангаж ажилласан байх	
	3.4. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгасан байх		Зөрчлийн тоогоор	Зөрчил бүрт хариуцлага тооцсон байх	
4. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	4.1. Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах	11-12 сард	Авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулсан байна. /хэлэлцүүлэг, өдөрлөг/	Төсөвт байгууллага бүр энэ өдрийг угтан бүтээлч ажил зохион байгуулах уламжлал тогтоох	ЗДТГ болон харьяа төсөвт байгууллагууд, Баг
	4.2. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, албан хаагчдын ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг авсан байх	Жилийн турш	Төрөл бүрийн арга хэмжээ төлөвлөн хийх	Авлига гарах эрсдлийг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээнүүд хийгдсэн байна.	
	4.3. Авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм, журмыг цахим сайт болон мэдээллийн самбарт байрлуулах,		Мэдээлэл олон нийтэд төрөл бүрийн мэдээллийн сувгаар хүрсэн байна	Мэдээлэл олон нийтэд төрөл бүрийн мэдээллийн сувгаар хүрсэн байна	
5. Бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах	5.1. Бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах зарыг цахим хуудас, хэвлэл мэдээллээр хугацаанд нь мэдээлсэн байх -Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр /төсвийн хөрөнгө оруулалтын задаргаа/ мэдээлсэн байх	Жилийн турш	Зарлагдсан ажлын тоогоор	Сонгон шалгаруулалтын зар олон нийтэд хуульд заасны дагуу хүрч хэвшсэн байна.	ЗДТГ болон Санхүүгийн алба
	5.2. Үнэлгээний хороонд сонирхлын зөрчилгүй хөндлөнгийн төлөөллийг оролцуулсан байх		Ажлын тоогоор	Хөндлөнгийн төлөөлөл ажилласан байна.	
	5.3. Бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн,	Тухай бүр	Үүргийн биелэлт хангагдаагүй тухай бүр бүртгэлд оруулах	Бүртгэлтэй болсон байх	

	хуулийн этгээдийн бүртгэлийг бий болгож, Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэх				
6. Захиргааны хариуцлагын тогтолцоог үр дүнтэй ашиглах	6.1. Хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр шийдвэр гаргаж, албан хаагчдад мэдэгдэх	Хагас, бүтэн жилээр	Шийдвэр гаргаж, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг тооцох	Сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр шийдвэр гарч, хэрэгжилт тооцогдсон байна.	ЗДТГ болон харьяа төсөвт байгууллагууд
	6.2. Захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулсан байх		2 удаагийн сургалт зохион байгуулсан байх	Ажилтнуудын сахилга бат сайжирсан байна	
	6.3. Аливаа зөрчилд ногдуулах хариуцлагын талаар албан хаагчдад танилцуулж, баталгаа авсан байх	Тухай бүр	2-оос доошгүй удаа мэдээлэл өгч, сануулах, баталгаа авч гарын үсэг зуруулах	Баталгаа гаргуулж, урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарсан байх	
	6.4. Зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцсон байх		Тухай бүр	Зөрчил бүрт хариуцлага тооцдог нөхцөл бүрдсэн байх	
7. Төрийн байгууллагын ил тод байдлыг хангаж ажиллах	7.1. Салбарын хэмжээнд болон үйл ажиллагаандаа мөрдөж буй дүрэм, журам, шийдвэрийн жагсаалтыг гаргаж иргэдэд ойлгогдохуйцаар цахим сайт болон мэдээллийн самбарт байрлуулсан байх	Тухай бүр	Шинээр дүрэм, журам батлагдах тоогоор	Иргэд мэдээллээр хангагдах боломж, орчин бүрдсэн байна.	ЗДТГ болон харьяа төсөвт байгууллагууд
	7.2. Хууль, тогтоомж, дүрэм, журам, шаардлагатай маягыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх		Мэдээллийг цаг тухайд нь байршуулж, баяжуулсан байна.	Иргэд төрийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл цаг тухайд нь авах боломж бүрдэх	
	7.3. Эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй шийдвэрийг ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлж, төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирэмж/-ийг нээлттэй байлгана.	Жилийн турш	Төрийн болон байгууллагын нууцад хамруулснаас бусад эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй шийдвэрийг гарсан тухай бүрт цахим хуудас болон боломжит хэлбэрээр олон нийтэд мэдээлнэ.	Иргэд олон нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангана.	
	7.4. Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсанд баайршуулж, иргэд олон нийт, сонирхогч бүлгийн санал солилцох боломжийг бүрдүүлж ажиллах		Шийдвэр гаргах түвшинд иргэд олон нийтийн саналыг тусгадаг болно	ИТХ, түүний ажлын алба, ЗДТГ болон харьяа төсөвт байгууллагууд, журмын төслийг боловсруулсан	

			утсаар санал авах, Facebook, Twitter, хуудсаар, бичгээр санал авах		холбогдох мэргэжилтэн нар
	7.5. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрлийг олгох журам, холбогдох бичиг баримтын жагсаалт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилнэ.	Жилийн турш	Чиг үүргийн дагуу олгогдож байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллүүд аймгийн байгууллагын цахим хуудсанд байршсан байна	Иргэд, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид мэдээллээр хангагдана. Төрийн байгууллагын үйл ажиллагааны хөндлөнгийн хяналт сайжирна.	Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
8. Байгууллагын төсвийг төлөвлөгдсөн зардалд үр ашигтай зарцуулах	8.1. Байгууллагын төсвийг төлөвлөгдсөн зардалд үр ашигтай зарцуулна	Төсвийн зүйл, зардлын тоогоор	Төсвийн зарцуулалт нийтэд ил тод мэдээлэгдсэн байх	Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	ЗДТГ болон харьяа төсөвт байгууллагууд, Санхүүгийн алба
	8.2. Төсөв, санхүүгийн тайланг сар, улирал, жилээр хугацаанд нь гаргаж холбогдох дээд байгууллагад тайлагнах, цахим хуудсанд байршуулах	Хуулинд заасан хугацаанд	Мэдээллүүдийг цахим хуудас, самбарт нийтэд ойлгогдохуйцаар байршуулах	Хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	
9. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	9.1. Төрийн албан хаагчид авлигаас ангид байх арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилах ажлыг зохион байгуулах	6, 11 дүгээр сард	Авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган, арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна. Төсөвт байгууллагын удирдлагууд авлигаас ангид байх хүсэл сонирхлоо иргэдэд илэрхийлсэн байна.	Төлөвлөгөөний дагуу арга хэмжээнүүдийг үр дүнтэй зохион байгуулсан байна.	ЗДТГ, 8-н баг болон харьяа төсөвт байгууллагууд
	9.2. Нийтийн албан хаагчдын дунд авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулна	1 удаа	Тодорхой сэдвүүдийн дагуу сургалт зохион байгуулах	Нийтийн албан хаагчдын мэдлэг сайжирсан байна.	ЗДТГ болон харьяа төсөвт байгууллагууд Хууль зүйн хэлтэстэй хамтрах

	<p>9.3. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчилах ажлыг төрийн бүх байгууллагууд зохион байгуулж ажиллана.</p> <p>Үүнд: Мэдээллийн самбар, цахим хуудас, телевизийн нэвтрүүлэг, сонсгол, өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал зэрэг орно.</p> <p>Зохион байгуулсан үйл ажиллагааны талаар холбогдох баримтууд буюу оролцогчдын бүртгэл, фото зураг, зохион байгуулсан арга хэмжээний хөтөлбөр, тайлан гэх мэт мэдээллийг баримтжуулсан байна.</p>	Жилийн турш	ЗДТГ болон төсөвт байгууллагууд иргэдэд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилах олон нийтийн арга хэмжээ, төрийн албан хаагчдын хуулийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байна.	Сумын ЗДТГ нийт иргэдийнхээ 5%, төсвийн байгууллагууд 150-аас доошгүй иргэдэд авлигын эсрэг хууль тогтоомжийн мэдээллийг боломжит хэлбэрээр хүргэсэн байна.	ЗДТГ, 8-н баг болон харьяа төсөвт байгууллагууд
10. Хяналт шинжилгээний орон тооны бус багийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах	10.1. Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний үр дүн. Хяналт шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллана. Хяналт шалгалтын дагуу зөвлөмж эвлөгөө өгөх арга хэмжээг зохион байгуулах	Жилийн турш	Хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөг байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулан, зохион байгуулсан үйл ажиллагааны холбогдох баримтыг баримтжуулсан байна.	Байгууллага олон талт хамтын ажиллагаа сайжирна	ЗДТГ, 8-н Баг болон харьяа төсөвт байгууллагууд ХШҮ баг
11. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангаж ажиллах	11.1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу холбогдох мэдээллүүдийг цахим хуудсанд тогтмол байршуулж, өөрчлөлт орох бүрт шинэчилж ажиллах	Жилийн турш	Холбогдох мэдээллийг тогтмол байршуулж, сонирхсон иргэдийг мэдээллээр хангаж ажилласан байна.	Төрийн албаны хүний нөөцийн ил тод байдал хангагдана	ЗДТГ болон харьяа төсөвт байгууллагууд

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР